



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/106/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Аудитор Д.Мөнжжин  
Утас: 260512 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит" ХХК-ийн  
захирал С.Должинсүрэн  
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Улаанбаатар хот  
2022 он

## АГУУЛГА

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Аудитын илрүүлэлт.....	14
7.1 Залруулсан алдаа.....	15
7.2 Зөвлөмж.....	15
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

## Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨААНБ	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЯ	Эрчим хүчний яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2022.03.15 № 07/523  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд аудитаар нийт 321.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Аудитын онцлог зүйлс

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын дүрэмд 15 төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тодорхойлсон боловч тайлант онд 2 төсөл хөтөлбөрт техникийн хяналтыг хэрэгжүүлэх, 1 төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, техникийн хяналт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, угсралт суурилуулалтын ажил гүйцэтгэхээр орлогын төлөвлөгөөнд тусгасан нь үйл ажиллагааны хүрээг хязгаарлаж, орлого бүрдүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллаагүй байна.

## **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 424 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөнд нийт орлогыг 489.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 489.0 сая төгрөгөөр буюу ашиг, алдагдалгүй ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 436.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 702.2 сая төгрөгийн зардал гарган, 265.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Нийт авлагыг 213.9 сая төгрөгөөр баталснаас 235.4 сая, нийт өглөгийг 393.2 төгрөгөөр баталснаас 533.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь зорилтот түвшний төлөвлөгөөг ханган биелүүлээгүй, удирдлагын менежмент хангалтгүй байна.

## **Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ нь 2021 онд 7 зорилтот бүлгийн хүрээнд 40 арга хэмжээ төлөвлөснөөс 97.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,340,894.24	397,322.95
1.1.2	Дансны авлага	213,894,749.12	214,201,122.12
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	7,350.00	-
1.1.4	Бусад авлага	29,840,200.21	21,211,649.71
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	165,334,265.77	150,306,128.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,894,851.71	408,435.90
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>417,312,311.05</b>	<b>386,524,659.51</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,741,059,839.20	1,696,492,421.57
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,741,059,839.20</b>	<b>1,696,492,421.57</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,158,372,150.25</b>	<b>2,083,017,081.08</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	84,634,532.49	94,416,007.69
2.1.1.2	Цалингийн өглөг	707,850.98	10,684,870.89
2.1.1.3	Татварын өр	144,518,525.69	175,441,122.56
2.1.1.4	НДШ-ийн өглөг	51,521,086.49	128,300,980.35
2.1.1.5	Богино хугацаат зээл	49,326,244.74	49,326,244.74
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	70,390,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	19,378,459.84	4,563,793.09
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>350,086,700.23</b>	<b>533,123,019.32</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>350,086,700.23</b>	<b>533,123,019.32</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	663,670,844.58	663,670,844.58
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,131,277,077.24	1,131,277,077.24
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	53,340,848.30	53,340,848.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(33,011,854.85)	(298,394,708.36)
	Тайлангийн үеийн ашиг		(265,382,853.51)
	Өмнөх үеийн	(40,003,320.10)	(33,011,854.85)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,808,285,450.02</b>	<b>1,549,894,061.76</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,158,372,150.25</b>	<b>2,083,017,081.08</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

				<i>/төгрөгөөр/</i>	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31		
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>629,571,144.00</b>	<b>310,212,080.82</b>		
2	Борлуулалтын өртөг	124,436,787.34	97,774,885.50		
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>505,134,356.66</b>	<b>212,437,195.32</b>		
4	Түрээсийн орлого	23,318,181.82	37,726,181.82		
5	Хүүгийн орлого	194,739.67	-		
6	Ногдол ашгийн орлого	-	-		
7	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	-	-		
8	Бусад орлого	-	88,902,367.88		
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	604,095,096.30	577,751,500.26		
11	Санхүүгийн зардал	-	-		
12	Бусад зардал	-	-		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	(49,806.05)	(123,143.74)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-		
17	Бусад ашиг (алдагдал)	(3,895,593.68)	(26,573,954.53)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(79,393,217.88)</b>	<b>(265,382,853.51)</b>		
19	Орлогын татварын зардал	216,627.54	-		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(79,609,845.42)</b>	<b>(265,382,853.51)</b>		
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>				
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(79,609,845.42)</b>	<b>(265,382,853.51)</b>		

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						<i>/төгрөгөөр/</i>	
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн		
<b>2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>663,670,844.58</b>	<b>1,131,277,077.24</b>	<b>53,340,848.30</b>	<b>39,606,525.32</b>	<b>1,887,895,295.44</b>		
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	<b>663,670,844.58</b>	<b>1,131,277,077.24</b>	<b>53,340,848.30</b>	<b>39,606,525.32</b>	<b>1,887,895,295.44</b>		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(79,609,845.42)	<b>(79,609,845.42)</b>		
<b>2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>663,670,844.58</b>	<b>1,131,277,077.24</b>	<b>53,340,848.30</b>	<b>(40,003,320.10)</b>	<b>1,808,285,450.02</b>		
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				6,991,465.25	<b>6,991,465.25</b>		
Залруулсан үлдэгдэл	<b>663,670,844.58</b>	<b>1,131,277,077.24</b>	<b>53,340,848.30</b>	(33,011,854.85)	<b>1,815,276,915.27</b>		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(265,382,853.51)	<b>(265,382,853.51)</b>		
<b>2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>663,670,844.58</b>	<b>1,131,277,077.24</b>	<b>53,340,848.30</b>	<b>(298,394,708.36)</b>	<b>1,549,894,061.76</b>		

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>625,193,950.61</b>	<b>500,904,129.09</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	575,436,263.97	378,370,612.74
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,333,844.00	400,829.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	48,423,842.62	122,132,687.35
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>650,617,977.84</b>	<b>503,847,700.38</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	209,780,535.57	202,694,555.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,208,985.47	500,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	57,343,161.25	26,386,902.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	20,378,133.59	17,826,789.59
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,837,000.00	10,575,790.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	16,878,854.96	499,693.65
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	791,856.00	1,480,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	310,399,451.00	243,883,970.02
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(25,424,027.23)</b>	<b>2,943,571.29</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>194,739.67</b>	<b>-</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	194,739.67	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>-</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Бусад	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>-</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>-</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(25,229,287.56)</b>	<b>2,943,571.29</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>28,570,181.80</b>	<b>3,340,894.24</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,340,894.24</b>	<b>397,322.95</b>



## 2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>						
	а) Гол нэр төрлөөр						
	б) Үнийн дүнгээр	сая.төг	653.1	489.0	436.8	(52.2)	89.3
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	сая.төг	<b>653.1</b>	<b>489.0</b>	<b>436.8</b>	(52.2)	89.3
	Үүнээс: -Цэвэр борлуулалт	сая.төг	629.8	451.5	399.1	(52.4)	88.4
	-Түрээсийн орлого	сая.төг	23.3	37.5	37.7	0.2	100.5
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	сая.төг	<b>732.5</b>	<b>489.0</b>	<b>702.2</b>	<b>213.2</b>	<b>143.6</b>
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	124.4	40.6	97.8	57.2	240.8
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	608.1	448.4	604.5	156.1	134.8
<b>4</b>	<b>Татварын өмнөх ашиг</b>	сая.төг	<b>(79.4)</b>		<b>(265.4)</b>	<b>(265.4)</b>	
<b>5</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	сая.төг	<b>(79.6)</b>		<b>(265.4)</b>	<b>(265.4)</b>	
<b>6</b>	<b>Төрийн өмчийн ногдол ашиг</b>	сая.төг	<b>44.6</b>				
<b>7</b>	<b>Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал</b>	сая.төг	<b>1.1</b>	<b>1.0</b>	<b>1.6</b>	<b>0.6</b>	<b>160.8</b>
<b>8</b>	<b>Нийт авлага</b>	сая.төг	<b>243.7</b>	<b>213.9</b>	<b>235.4</b>	<b>21.5</b>	<b>110.1</b>
	0-5 жилийн насжилттай	сая.төг	179.8	143.5	172.3	28.8	120.1
	5-10 жилийн насжилттай	сая.төг	64.0	70.4	63.1	(7.2)	89.7
<b>9</b>	<b>Нийт өглөг</b>	сая.төг	<b>350.1</b>	<b>393.2</b>	<b>533.1</b>	<b>139.9</b>	<b>135.6</b>
	Үүнээс: - Богино хугацаат өр төлбөр	сая.төг	350.1	393.2	533.1	139.9	135.6
<b>10</b>	<b>Хөрөнгө оруулалт их засвар</b>	сая.төг	-	-	-	-	-
<b>11</b>	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	тоо	<b>26</b>	<b>39</b>	<b>25</b>	<b>(5)</b>	<b>64.1</b>
<b>12</b>	<b>Нийт цалингийн сан</b>	сая.төг	<b>255.9</b>	<b>259.5</b>	<b>260.6</b>	<b>1.1</b>	<b>100.4</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, авлага, өглөгийн данс, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 06-ны хооронд Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудиторын туслах А.Сандра нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсээс тус газрын 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/32 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалтын орон тооны бус зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2021 оны 12 дугаар сард 4 ажил төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 653.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын зорилго нь сэргээгдэх эрчим хүчний нөөцийн нарийвчилсан хэмжилт судалгаа хийх, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж, барилга байгууламжид техникийн хяналт тавих, засвар үйлчилгээ үзүүлэх, сорилт, туршилт, хөндлөнгийн магадалгаа нотолгоо хийх, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахад оршино.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах нөөцийн судалгаа хийх;
- Сэргээгдэх эрчим хүчний шинэ техник, технологи судалж нэвтрүүлэн нутагшуулах,
- Сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, усны эрчим болон газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний чиглэлээр улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, Хөгжлийн банк, бондын хөрөнгө, төр, хувийн хэвшлийн гүйцэтгэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, усны эрчим болон газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний чиглэлээр хувийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн захиалагч, техникийн хяналтын үүрэг гүйцэтгэх;
- Сэргээгдэх эрчим хүчний зураг төсөл боловсруулах;
- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан технологийн төсөл боловсруулах;
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжид хэмжилт судалгаа, сорилт, туршилт, хөндлөнгийн магадалгаа нотолгоо хийх;
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээртэй холбоотой судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, засвар үйлчилгээ үзүүлэх;
- Шинээр баригдах эрчим хүчний эх үүсгүүр болон өргөтгөл зэрэгт хүлэмжийн хийн ялгарлын бууралтад магадалгаа, нотолгоо хийх;
- Олон улсын байгууллагатай сэргээгдэх эрчим хүчний бүх чиглэлд хамтран ажиллах;
- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр сургалт зохион байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гадаад, дотоод худалдаа эрхлэх;
- Нарны зайн үйлдвэрлэл, угсралт, тохируулга, засвар үйлчилгээ үзүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, сангийн орлогоор тухайн чиглэлийн дүрэм, журам, норматив, стандартыг шинэчилж сайжруулах;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа.

## 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ыг Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 80 дугаар тэмдэглэлийг үндэслэн ТӨХ-ны 2009 оны 58, 146 дугаар тогтоолоор Нарны зайн үйлдвэрийг түшиглэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд тайлант онд тодорхой өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй бөгөөд Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шууд болон шууд бус удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт ороогүй, удирдлага, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлээгүй, тогтоолын заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл хангалтгүйгээс тайлант онд батлагдсан төлөвлөгөөгөөр 39 орон тоотой ажиллахаас 25 орон тоотой ажиллаж, үүнээс 16 ажилтан буюу 64.0 хувь нь ажлаас чөлөөлөгдөж өөрчлөлт орсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль /2021.07.02/;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам".

## 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.3	0.4	(2.9)
Авлага	243.8	235.4	(8.4)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	4.9	0.4	(4.5)
Бараа материал	165.3	150.3	(15.0)
Үндсэн хөрөнгө	1,741.1	1,696.5	(44.6)
Биет бус хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,158.4</b>	<b>2,083.0</b>	<b>(75.4)</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>350.1</b>	<b>533.1</b>	<b>183.0</b>
Богино хугацаат өглөг	350.1	533.1	183.0
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	1,808.3	1,549.9	(258.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,158.4</b>	<b>2083.0</b>	<b>(75.4)</b>

Авлагын үлдэгдэлд 2003-2019 онд үүссэн 8 байгууллага, 19 хувь хүнтэй холбоотой 235.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс гэрээний дагуу нийлүүлэгдсэн 170.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр авлагыг бууруулаагүй, хугацаа хэтэрсэн 65.4 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Найдваргүй авлагыг хасагдуулгын аргаар тооцдог бөгөөд тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1238 дугаар албан бичгийг үндэслэн 7.2 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлээс хассан байна.

Бараа материал худалдаж авсан 51.4 сая, дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэгдэж байсан хөрөнгийг бусад хангамжийн материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн 10.1 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 66.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө Эрчим хүчний сайдын 2019 оны А/3875 дугаар албан бичгийн дагуу Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 76.4 сая төгрөгийн үнэ бүхий салхины нөөцийн хэмжилтийн тоног төхөөрөмжийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 286 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 154.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий Лексус LX570 маркийн автомашиныг “Архангай АЗЗА” ТӨХК-д балансаас баланст шилжүүлсэн дүнгээр буурсан байна.

Тайлант оны эцэст богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 533.1 сая төгрөг болж 183.0 сая төгрөгөөр өссөн нь дансны өглөг 9.8 сая төгрөг, татварын өглөг 30.9 сая төгрөг, НДШ-ийн өглөг 76.8 сая төгрөг, урьдчилж орсон орлого 70.4 сая төгрөгөөр өсөж, бусад богино хугацаат өр төлбөр 14.8 сая төгрөгөөр буурсан нь шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд НДШ-ийн 128.3 сая, ААНОАТ-ын 17.2 сая, ХХОАТ-ын 58.2 сая, НӨАТ-ын 75.2 сая, ҮХЭХАТ-ын 24.8 сая, нэр бүхий 11 байгууллагад төлөх 27.7 сая, ажилчин албан хаагчдад төлөх 21.1 сая, цалингийн 10.7 сая, төрийн өмчийн түрээсийн 45.6 сая төгрөг, урьдчилж орсон орлогын 70.4 сая төгрөг, бусад байгууллагад төлөх 53.9 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэлтэй байна.

Өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь борлуулалтын орлогын тасалдал, авлага цуглуулалтаас шалтгаалж байгаа бөгөөд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, төлбөрийн чадвар доройтох үр дагавартай байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1,549.9 сая төгрөг болж 258.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдвэрлэл, үйлчилгээний өртөг буюу борлуулсан бүтээгдэхүүний өртөг зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг зардал нь хөрөнгийг бууруулах, өр төлбөрийг өсгөхөөр байвал орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулалтын өртөг, ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилсан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2021 оны 424 дүгээр тогтоолоор Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг тодотгон баталж, тайлант оны нийт орлогыг 489.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 489.0 сая төгрөгөөр буюу ашиг, алдагдалгүй ажиллахаар тогтоосон бөгөөд хөрөнгө оруулалтын зардал батлаагүй байна.

Гүйцэтгэлээр 436.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 702.2 сая төгрөгийн зардал гарган, 265.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 436.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 52.2 сая төгрөг буюу 10.7 хувиар тасарсан нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2021 онд хэрэгжихээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүд хойшилсон, төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй зэрэг шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 702.2 сая төгрөг болж өмнөх оноос 30.3 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан хэдий ч төлөвлөснөөс 213.2 сая төгрөг буюу 43.6 хувиар хэтэрсэн байна. Энэ нь тодотгосон төлөвлөгөөг 2021 оны 10 дугаар сард батлахаас өмнө үндсэн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай зардлууд гарсан, орлого зардлын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн уялдаа холбоо хангагдаагүй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 5 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 65.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч тайлант онд төлөвлөсөн ажлууд хийгдээгүй байна.

Тайлант онд тодотгосон төлөвлөгөөгөөр ашиг, алдагдалгүй ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 265.4 сая төгрөгийн алдагдалтай байгаа нь төлөвлөснөөс нийт орлого 52.2 сая төгрөгөөр тасарч, нийт зардал 213.2 сая төгрөг буюу 43.6 хувиар өссөн нь нөлөөлж байна.

Тайлант онд төвлөрүүлэх түрээсийн орлогын 40.0 хувь буюу 15.4 сая төгрөгөөс 7.8 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлж, 45.6 сая төгрөгийн дутуу төлөлтийг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

#### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

## 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулан эсэхийг хамруулан шалгалаа.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ нь тайлант онд нийт 671.5 сая төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

ЭХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Эрчим хүчний салбарын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, тус газрын шилэн дансны хөтлөлтийг 96.6 хувиар дүгнэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТӨБЗГ-ын 2021 оны 424 дүгээр тогтоолоор баталсан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөгөөр нийт орлогыг 489.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 489.0 сая төгрөгөөр буюу ашиг, алдагдалгүй ажиллахаар тогтоосон. Гүйцэтгэлээр 436.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 702.2 сая төгрөгийн зардал гарган, 265.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, нийт авлагыг 213.9 сая төгрөгөөр баталснаас 235.4 сая, нийт өглөгийг 393.2 төгрөгөөр баталснаас 533.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжийг зөв тодорхойлж, орлогыг нэмэгдүүлэх зах зээлийн боломжийг судлан бодитой төлөвлөж, төлөвлөгөөг ханган биелүүлэхэд удирдлага, хамт олны идэвх санаачилгыг дээшлүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 57.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 6.7 сая төгрөгийг залруулж, 51.0 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 10.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага болон зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

## 7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 410.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 88.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 321.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 321.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 13.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

## 7.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 76.4 сая төгрөг тоног төхөөрөмж, 12.5 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны бус орлого нийт 88.9 сая төгрөгийг борлуулалтын орлогод бүртгэж тайлагнасныг бусад орлогоор тооцон залруулсан.

## 7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 32 нэрийн 50.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг бүртгэсэн байна. Энэ нь Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 9.3-д "Үндсэн хөрөнгө - Нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах үйлдвэрлэл, үйлчилгээ буюу захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө" гэж заасантай нийцэхгүй байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн шинж чанар, үр өгөөжийг үндэслэн зөв ангилан бүртгэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

### 2. Авлагын данстай холбоотой асуудал

#### 2.1 Илрүүлэлт:

Авлагын үлдэгдэлд 2003-2019 онд үүссэн 8 байгууллага, 19 хувь хүнтэй холбоотой 235.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс гэрээний дагуу нийлүүлэгдсэн 170.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр авлагыг бууруулаагүй, 65.4 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 6.5-д "Тухайн аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлага нь авлагын үлдэгдлийг бууруулах талаар байнга анхаарч, хяналт тавьж ажиллана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж:

Хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнгээр авлагыг бууруулах бичилтийг хийх, найдваргүй авлагын шалтгааныг тодорхойлж, авлагыг барагдуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

### 3. Өглөгийн данстай холбоотой асуудал

#### 3.1 Илрүүлэлт:

Тайлант оны эцэст богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 533.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Үүнээс 12 байгууллагын 35.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 12.4-д "Санхүүгийн алба нь байгууллагын өр төлбөрийн эргэн төлөлтийг зохицуулах, холбогдох шинжилгээг хийж, өр төлбөрийн насжилтыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах ..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.



**3.2 Өгсөн зөвлөмж:**

Харилцагч байгууллагатай хийх тооцоог улирал тутам тооцоо нийлж баталгаажуулан, санхүүгийн тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Запруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ	АХГ-2022/106/НА-СТА-ТӨА	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 32 нэрийн 50.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг бүртгэсэн.	Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 9.3, НББОУС 16.6, 16.15-д заасны дагуу хөрөнгийг үнэн зөв бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.	1	50,958.0							1	50,958.0
2	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ	АХГ-2022/106/НА-СТА-ТӨА	Авлагын үлдэгдэлд 2003-2019 онд үүссэн 8 байгууллага, 19 хувь хүнтэй холбоотой 235.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс гэрээний дагуу нийлүүлэгдсэн 170.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр авлагыг бууруулаагүй, 65.4 сая төгрөгийн найдваргүй авлага байна.	Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 6.5-д заасныг хэрэгжүүлж насжилт өндөр, найдваргүй болсон авлагыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	1	235,412.7							1	235,412.7
3	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ	АХГ-2022/106/НА-СТА-ТӨА	Тайлант оны эцэст богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 533.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Үүнээс 12 байгууллагын 35.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Эрчим хүчний ТБОНӨААНБ-уудын мөрдөх НБББББ-ийн 12.4-д заасныг хэрэгжүүлэн тооцоо нийлж, өглөг барагдуулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	1	35,255.3							1	35,255.3
Дүн					3	321,626.0							3	321,626.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ	АХГ-2022/106/НА-СТА-ТӨА	ТӨБЗГ-ын 2021 оны 424 дүгээр тогтоолоор баталсан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн тодотгосон төлөвлөгөөгөөр нийт орлогыг 489.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 489.0 сая төгрөгөөр буюу ашиг, алдагдалгүй ажиллахаар тогтоосон. Гүйцэтгэлээр 436.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 702.2 сая төгрөгийн зардал гарган, 265.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Нийт авлагыг 213.9 сая төгрөгөөр баталсанаас 235.4 сая төгрөгийн	Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжийг зөв тодорхойлж, орлогыг нэмэгдүүлэх зах зээлийн боломжийг судлан бодитой төлөвлөж, төлөвлөгөөг ханган биелүүлэхэд удирдлага, хамт олны идэвх санаачлагыг дээшлүүлж ажиллах.	1	-						1	-	

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

		авлагатай, нийт өглөгийг 393.2 төгрөгөөр баталсанаас 533.1 сая төгрөгийн өглөгтэй байгаа нь зорилтот түвшний төлөвлөгөөг ханган биелүүлэхэд удирдлага санаачлага муутай ажилласан байна.											
		Дүн		1						1			
		<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>321,626.0</b>					<b>1</b>		<b>3</b>	<b>321,626.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 326/АО/СО055  
АХГ-2022/106/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 424 дүгээр тогтоолоор баталсан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөгөөр нийт орлогыг 489.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 489.0 сая төгрөгөөр буюу ашиг, алдагдалгүй ажиллахаар тогтоосон. Гүйцэтгэлээр 436.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 10.7 хувиар тасалж, 702.2 сая төгрөгийн зардал гарган, зардлын төлөвлөгөөг 43.6 хувиар хэтрүүлсэн, 265.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, нийт авлагын үлдэгдлийг 213.9 сая төгрөгөөр баталснаас 235.4 сая төгрөг буюу 10.0 хувиар их, нийт өглөгийн үлдэгдлийг 393.2 сая төгрөгөөр баталснаас 533.1 сая төгрөг буюу 67.0 хувиар илүү үүсгэн, зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Алтанцэцэг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Д.Дүүриймаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН СУВАРГА АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.ДОЛЖИНСҮРЭН

9006109  
9019120596

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-4.Docx

0010800953

## ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines provided for writing a summary.